



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Орон нутагт Үндэсний аюулгүй байдлыг
хангах ажлын хэсэг байгуулах,
ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.12 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 7 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй зөвлөлийн нарийн бичгийн даргын 2025 оны А/06 дугаар захирамж, Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндэсний аюулгүй байдлыг хангах орон нутгийн бодлого, төлөвлөгөө боловсруулж батлуулах, хууль тогтоомжид заасан эрх үүргийг хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Сүхболд)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ